



2019 оны 05 дугаар сарын 23  
№20/1073/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
хууль**

**Боловсролын тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах  
тухай хуульд өөрчлөлт  
орлуулах тухай**

**Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг**

**Шүүгчийн албан тушаалд  
шилжүүлэн томилох тухай**

**Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол**

**Журам, чиглэл батлах  
тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

167.	Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		637
<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b>			
168.	Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай	Дугаар 75	637
<b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b>			
169.	Журам, чиглэл батлах тухай	Дугаар 43	638
170.	Журам батлах тухай	Дугаар 64	646
171.	Үндэсний хөтөлбөр батлах тухай	Дугаар 68	653

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

#### **БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөр баталсан Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс” гэснийг “2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 05 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

#### **Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



1. Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Пүрэвдоржийн Баясгаланг Багахангай дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Алагаагийн Мөнхзулыг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Төмөрбаатарын Ганчимэгийг Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус шилжүүлэн томилсугай.

2. Адил шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох болсонтой холбогдуулан Пүрэвдоржийн Баясгаланг Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Алагаагийн Мөнхзулыг Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Төмөрбаатарын Ганчимэгийг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 1 дүгээр  
сарын 23-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар  
хот

### Журам, чиглэл батлах тухай

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.9-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтанд авах журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Отор, нүүдлийн зорилгоор аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэл”-ийг 2 дугаар хавсралт, “Мах бэлтгэлийн зорилгоор аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэл”-ийг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газар (Д.Түмэндэмбэрэл), бүх шатны Засаг дарга нарт, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаанд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

**Ч.УЛААН**

МАЛ, АМЬТНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОХИЦУУЛАХ,  
ТЭЭВЭР, ТУУВРЫН ЗАМД СААТУУЛЖ, ХОРИО  
ЦЭЭРИЙН ХЯНАЛТАД АВАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт отор, нүүдэл хийх, мал, амьтныг үзэсгэлэн худалдаа, нийтийг хамарсан уралдаан, тэмцээнд оролцуулах, хүнс, арилжаа, бэлэглэл, үржлийн зориулалтаар тээвэрлэх, тууварлах болон мал бүхий иргэд оршин суугаа газраасаа өөр аймаг, хот, сумын нутаг дэвсгэрт шилжин суурьших зорилгоор хийх мал, амьтны шилжилт, хөдөлгөөнийг зохицуулахад энэ журмыг баримтална.

Хоёр. Отор, нүүдлийн зорилгоор хийх мал, амьтны  
шилжилт хөдөлгөөнийг зохицуулах

2.1. Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрт нь отор, нүүдэл хийхээр өөр аймаг, нийслэл, сум, дүүргийн нутгийн захиргааны байгууллага (цаашид “шилжүүлэгч тал” гэх)-аас гаргасан хүсэлтийг харьяа мал эмнэлгийн газар (тасаг)-ын саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

2.2. Мал эмнэлгийн газар (тасаг) нь энэ журмын 2.1-д заасан саналыг гаргахдаа шилжин ирэхээр төлөвлөж байгаа нутаг дэвсгэр дэх мал, амьтны гоц халдварт, халдварт болон шимэгчтэх өвчний тархвар зүйн судалгаа, хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх мэдээллийг харгалзан үзнэ.

2.3. Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ отор, нүүдэл хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нь шилжүүлэгч талтай гэрээ байгуулж, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.11-д заасны дагуу шилжүүлэгч талаас эрүүл мэндийн тодорхойлолтыг гаргуулан авна.

2.4. Энэ журмын 2.3-т заасан гэрээнд отор, нүүдэл хийх мал, амьтны төрөл, тоо, отор, нүүдэл хийх чиглэл, хугацаа, нутаг дэвсгэрийг заана.

2.5. Шилжүүлэгч тал нь отор, нүүдэл хийх мал сүргийг гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулсан байна.

2.6. Шилжүүлэгч болон хүлээн авагч талын Засаг дарга отор, нүүдлийн шилжилт хөдөлгөөнийг зохион байгуулах, хяналт тавих хамтарсан ажлын хэсгийг байгуулна.



2.7. Хамтарсан ажлын хэсэг нь отор, нүүдэл хийх явцад болон гэрээгээр тогтоосон нутаг дэвсгэрт зүй бусаар хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, бэлчээр, уст цэг, үерийн жалга, усны эх булгийг цэвэрлэх, хашаа, хороог халдваргүйжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.8. Энэ журмын 2.7-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг шилжүүлэгч тал хариуцна.

Гурав. Отор, нүүдлээс бусад зорилгоор хийх мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах

3.1. Малчин, мал бүхий иргэн оршин суугаа газраасаа өөр аймаг, хот, сумын нутаг дэвсгэрт шилжин суурьших, үзэсгэлэн, худалдаа, уралдаан, тэмцээнд оролцох, эсхүл үржлийн болон хүнс, арилжаа, бэлэглэлийн зориулалтаар мал, амьтныг тууварлах, тээвэрлэх бол Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.4-т заасан шаардлагыг урьдчилан хангасан байна.

3.2. Үржлийн мал, амьтныг худалдах, худалдан авахтай холбогдсон шилжилт хөдөлгөөнийг тухайн мал, амьтныг эрүүл болохыг нотолсон мал эмнэлгийн гэрчилгээг үндэслэн хийнэ.

3.3. Энэ журмын 3.2-т заасан гэрчилгээг тухайн орон нутгийн гэрээт мал эмнэлгийн нэгжийн эрүүл мэндийн тодорхойлолтыг үндэслэн сумын мал эмнэлгийн тасаг олгоно.

3.4. Халдварт өвчингүй, тайван болон тусгаарласан бүс нутаг руу мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийхдээ тухайн бүсэд мөрдөхөөр мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврыг дагаж мөрдөнө.

3.5. Байгалийн аюулт үзэгдлийн улмаас уруудсан мал, амьтныг буцаан тээвэрлэж, тууварлахаас өмнө тухайн мал, амьтан очсон нутаг дэвсгэрийн гэрээт мал эмнэлгийн нэгж үзлэг хийж, эрүүл мэндийн тодорхойлолт олгосон байна.

3.6. Энэ журмын 3.5-д заасан эрүүл мэндийн тодорхойлолтыг үндэслэн сумын мал эмнэлгийн тасгаас гэрчилгээ олгосны дараа уг мал, амьтныг тээвэрлэх, эсхүл тууварлана.

3.7. Олон улсын болон улсын чанартай авто зам дамжин өнгөрдөг аймаг, сумын нутаг дэвсгэрт мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийх үед түр саатах, түр амраах цэгийг мал эмнэлгийн газар, тасгийн улсын байцаагчийн саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга тогтоож, нийтэд мэдээлнэ.

Дөрөв. Мал, амьтныг тээвэр, тууврын замд саатуулж,  
хорио цээрийн хяналтад авах

4.1. Хяналтын цэгийн болон мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.6-д зааснаас гадна дараахь тохиолдолд мал, амьтныг тээвэрлэх, тууварлах замд саатуулж, хорио цээрийн хяналтад авна:

4.1.1. мал эмнэлгийн гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан;

4.1.2. мал эмнэлгийн гэрчилгээнд бичигдсэн тээврийн хэрэгсэл солигдсон;

4.1.3. мал эмнэлгийн гэрчилгээнд бичигдсэн мал, амьтны төрөл, тоо, зүс, ялган тэмдэглэгээ нь цахим бүртгэлийн сангийн мэдээллээс зөрүүтэй;

4.1.4. гэрчилгээний хүчинтэй хугацаанд тухайн мал, амьтны гарал үүсэл бүхий нутаг дэвсгэрт нь халдварт өвчин шинээр оношлогдсон;

4.1.5. мал эмнэлгийн гэрчилгээнд бичигдсэн аймаг, сум дамжин өнгөрөх замын чиглэлийг зөрчсөн, дамжин өнгөрөх мал эмнэлгийн хяналтын цэгийн бүртгэл, тэмдэглэгээ хийгдээгүй, хяналтад ороогүй;

4.1.6. мал, амьтны халдварт өвчний голомт илэрсэн нутаг дэвсгэрээр тухайн тээврийн хэрэгсэл дамжин өнгөрсөн талаар мал эмнэлгийн байгууллагаас мэдээлэл ирүүлсэн.

4.2. Мал эмнэлгийн хяналтын цэгт болон тээвэр, тууврын замд мал, амьтан саатуулсан тохиолдолд мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.7-д заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.3. Энэ журмын 4.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу мал, амьтныг тээвэрлэж, тууварлаж, унаж эдэлж байгаа иргэн, хуулийн этгээд хариуцна.

4.4. Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь мал, амьтны шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан гарч болох халдварт өвчний хор хөнөөл, түүнээс сэргийлэх талаар иргэн, хуулийн этгээдэд ухуулга, сурталчилгаа хийх, мэдээллээр хангах ажлыг хариуцан хэрэгжүүлнэ.



Тав. Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

5.1. Мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийж буй иргэн, хуулийн этгээд нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.4-т зааснаас гадна дараахь үүрэг хүлээнэ:

5.1.1. тогтоосон замын чиглэлийн дагуу мал, амьтныг тээвэрлэж, тууварлах;

5.1.2. хүлээн авагч талын Засаг даргаас тогтоож өгсөн нутаг дэвсгэрт оторлох, нүүдэллэх;

5.1.3. мал, амьтныг тээвэрлэхдээ зориулалтын, эсхүл мал, амьтанд бэртэл гэмтэл учруулахгүй байхаар нэмж тоногосон тээврийн хэрэгслийг ашиглах, тээвэрлэхийн өмнө механик цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийлгэх;

5.1.4. отор, нүүдэл болон худалдах, арилжихаас бусад зорилгоор тээвэрлэж, тууварлаж яваа мал, амьтныг тухайн сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн зөвшөөрөлгүйгээр худалдаалах, солих, үлдээхгүй байх;

5.1.5. мал, амьтны шилжилт хөдөлгөөний үед хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг зөвшөөрсөн цэгт зааврын дагуу устгах;

5.1.6. шилжилт хөдөлгөөний үед мал, амьтны өвчний сэжиг илэрсэн тохиолдолд засаг захиргаа, мал эмнэлгийн байгууллагад яаралтай мэдээлэх;

5.1.7. мал, амьтан тээвэрлэх, тууварлах талаар эрх бүхий байгууллагаас баталсан журам, зааврыг мөрдөх;

5.1.8. олон улсын болон улсын чанартай авто зам дамжин өнгөрдөг аймаг, сумын нутаг дэвсгэрээр мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийх бол тогтоосон цэгт түр саатах, түр амраах.

5.2. Иргэн, хуулийн этгээд мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийхтэй холбоотой санал, гомдлоо холбогдох эрх бүхий байгууллагад гаргах эрхтэй.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Засгийн газрын 2019 оны 43 дугаар  
 тогтоолын 2 дугаар хавсралт

**ОТОР, НҮҮДЛИЙН ЗОРИЛГООР АЙМАГ ДАМЖИЖ МАЛ ТУУХ ТУУВРЫН ЗАМЫН ЧИГЛЭЛ**

№	Бүсчлэл	Отор, нүүдлээр ирэх чиглэл	Нэвтрэхгүй байх зураас сум, дүүрэг	Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн хяналтын түр цэг
1.	<b>БАРУУН БҮС:</b> Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэр	Төвийн бүсээс баруун бүсэд	Хөвсгөл аймгийн Тариалан, Рашаант, Их-Уул, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Галт, Жаргалант; Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл, Отгон; Баянхонгор аймгийн Гурванбулаг, Байдраг, Галуут, Эрдэнэцогт, Өлзийт, Жинст, Богд, Баянлиг, Шинэжинст	Сумдын мал эмнэлгийн тасаг, тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан мал эмнэлгийн хяналтын түр цэг
2.	<b>ТӨВИЙН БҮС:</b> Архангай, Булган, Орхон, Сэлэнгэ, Дархан- Уул, Өвөрхангай, Төв, Дундговь, Өмнөговь аймаг, Нийслэлийн нутаг дэвсгэр	Зүүн бүсээс төвийн бүсэд	Төв аймгийн Мөнгөнморьт, Баяндэлгэр, Архуст, Баянжаргалан; Нийслэлийн Багануур дүүрэг; Дундговь аймгийн Цагаандэлгэр, Баянжаргалан, Өндөршил; Өмнөговь аймгийн Манлай, Ханбогд	Сумдын мал эмнэлгийн тасаг, тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан мал эмнэлгийн хяналтын түр цэг
3.	<b>ЗҮҮН БҮС:</b> Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь аймгийн нутаг дэвсгэр	Төвийн бүсээс зүүн бүсэд	Хөвсгөл аймгийн Тариалан, Рашаант, Их-Уул, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Галт, Жаргалант; Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл, Отгон; Баянхонгор аймгийн Гурванбулаг, Байдраг, Галуут, Эрдэнэцогт, Өлзийт, Жинст, Богд, Баянлиг, Шинэжинст	Сумдын мал эмнэлгийн тасаг, тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан мал эмнэлгийн хяналтын түр цэг

Дээрх тогтоосон хязгаар давахгүйгээр отор нүүдэл хийсэн тохиолдолд очсон сумын хөдөө аж ахуйн тасагт бүртгүүлж, мал эмнэлгийн тасгийн хяналтанд орсон байна.





Засгийн газрын 2019 оны 43 дугаар  
тогтоолын 3 дугаар хавсралт  
МАХ БЭЛТГЭЛИЙН ЗОРИЛГООР АЙМАГ ДАМЖИЖ МАЛ ТУУХ ТУУВРЫН ЗАМЫН ЧИГЛЭЛ

№	Тэвэр, туувар хийх замын чиглэл	Хяналтад нь заавал хамрагдах байнгын ажиллагаатай усын мал эмнэлгийн хяналтын цэг	Хяналтад нь хамрагдах орон нутгийн мал эмнэлгийн хяналтын цэг
1	Баян-Өлгий-Ховд-Говь-Алтай-Нийслэлийн чиглэлийн төв зам болон зам дагуу Баян-Өлгий-Увс-Завхан аймгийн Тосонцэнгэл-Архангай-Нийслэлийн чиглэлийн төв зам болон зам дагуу	Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын "Таацын голын гүүр", Төв аймгийн Лүн сумын "Гүүрний ам", Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Шар хөтөл", Хан-Уул дүүргийн "Тавантолгойн гүүрний уулзвар" дахь мал эмнэлгийн хяналтын цэг Архангай аймгийн Цахир сумын "Солонготын давааны ам", Төв аймгийн Лүн сумын "Гүүрний ам", Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Шар хөтөл", Хан-Уул дүүргийн "Тавантолгойн гүүрний уулзвар" дахь мал эмнэлгийн хяналтын цэг	Говь-Алтай, Баянхонгор аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан түр ажиллагаатай мал эмнэлгийн хяналтын цэг Ховд, Увс, Завхан, Архангай, Өвөрхангай аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан түр ажиллагаатай мал эмнэлгийн хяналтын цэг
2	Хөвсгөл-Булган-Орхон-Дархан-Уул-Нийслэлийн чиглэлийн төв зам болон зам дагуу Хөвсгөл-Булган-Нийслэлийн чиглэлийн төв зам болон зам дагуу Өвөрхангай-Нийслэлийн чиглэлийн төв зам болон зам дагуу	Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Гуртын гүүр", Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Баруунтуруун", Хан-Уул дүүргийн "Тавантолгойн гүүрний уулзвар" дахь мал эмнэлгийн хяналтын цэг Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Гуртын гүүр", Төв аймгийн Лүн сумын "Гүүрний ам", Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Шар хөтөл", Хан-Уул дүүргийн "Тавантолгойн гүүрний уулзвар" дахь мал эмнэлгийн хяналтын цэг Төв аймгийн Лүн сумын "Гүүрний ам", Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Шар хөтөл", Хан-Уул дүүргийн "Тавантолгойн гүүрний уулзвар" дахь мал эмнэлгийн хяналтын цэг	Хөвсгөл, Булган, Орхон, Дархан-Уул, Төв аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан түр ажиллагаатай мал эмнэлгийн хяналтын цэг Хөвсгөл, Булган, Өвөрхангай, Төв аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан түр ажиллагаатай мал эмнэлгийн хяналтын цэг Өвөрхангай, Төв аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан түр ажиллагаатай мал эмнэлгийн хяналтын цэг

Архангай- Нийслэлийн чиглэлийн төв зам болон зам дагуу	Архангай аймгийн Цахир сумын “Солонготын давааны ам”, Төв аймгийн Лүн сумын “Гүүрний ам”, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Шар хөтөл”, Хан-Уул дүүргийн “Тавантолгойн гүүрний уулзвар” дахь мал эмнэлгийн хяналтын цэг	Архангай, Өвөрхангай, Төв аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан түр ажиллагаатай мал эмнэлгийн хяналтын цэг
Булган-Орхон-Дархан-Уул- Нийслэлийн чиглэлийн төв зам болон зам дагуу	Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Баруунтуруун”, Хан-Уул дүүргийн “Тавантолгойн гүүрний уулзвар” дахь мал эмнэлгийн хяналтын цэг	Булган, Орхон, Дархан-Уул, Төв аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан түр ажиллагаатай мал эмнэлгийн хяналтын цэг
Булган-Нийслэлийн чиглэлийн төв зам болон зам дагуу	Төв аймгийн Лүн сумын “Гүүрний ам”, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Шар хөтөл”, Хан-Уул дүүргийн “Тавантолгойн гүүрний уулзвар” дахь мал эмнэлгийн хяналтын цэг	Булган, Өвөрхангай, Төв аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан түр ажиллагаатай мал эмнэлгийн хяналтын цэг
Сэлэнгэ- Нийслэлийн чиглэлийн төв зам болон зам дагуу	Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Баруунтуруун”, Хан-Уул дүүргийн “Тавантолгойн гүүрний уулзвар” дахь мал эмнэлгийн хяналтын цэг	Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан түр ажиллагаатай мал эмнэлгийн хяналтын цэг
Өмнөговь- Нийслэлийн чиглэлийн төв зам болон зам дагуу	Нийслэлийн Хан-Уул дүүргийн “Өлзийт хорооллын уулзвар”, “Тавантолгойн гүүрний уулзвар” дахь мал эмнэлгийн хяналтын цэг	Өмнөговь, Дундговь, Төв аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан түр ажиллагаатай мал эмнэлгийн хяналтын цэг
Дорнод- Нийслэлийн чиглэлийн төв зам болон зам дагуу	Нийслэлийн Багануур дүүргийн “Хэрлэнгийн гүүр” дахь мал эмнэлгийн хяналтын цэг	Дорнод, Хэнтий, Төв аймаг, Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан түр ажиллагаатай мал эмнэлгийн хяналтын цэг
Замын-Үүд- Нийслэлийн чиглэлийн төв зам болон зам дагуу	Төв аймгийн Баян сумын “14 дүгээр зөрлөг” /нийслэлийн Багахангай дүүргийн хойд уулзвар/, Нийслэлийн Налайх дүүргийн “4 дүгээр зөрлөг”, Хан-Уул дүүргийн “Өлзийт хорооллын уулзвар”, “Тавантолгойн гүүрний уулзвар” дахь мал эмнэлгийн хяналтын цэг	Дорноговь, Говьсүмбэр, Төв аймаг, Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр байгуулсан түр ажиллагаатай мал эмнэлгийн хяналтын цэг

3

Жич: Нийслэл рүү нэвтрэхээс бусад тохиолдолд тухайн дамжин өнгөрөх аймгийн Засаг даргын шийдвэрээр тогтоосон замын чиглэлийг баримтлана.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 2 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.1, 9.2.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Гадаадын сурвалжлагчийг бүртгэх, Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрөл олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 97 дугаар тогтоолын 1 дэх заалтын “Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, гадаад улс, олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнийг бүртгэх журам” гэснийг “Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнийг бүртгэх журам” гэж өөрчилсүгэй.

3. Засгийн газрын 2012 оны 97 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнийг бүртгэх журам”-ын 1.1 дэх заалтын “заасан” гэснийг дараа “Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газарт ажиллах” гэж нэмсүгэй.

4. Мөн журмын нэрийг “Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнийг бүртгэх журам” гэж, 3.1 дэх заалтын “байгууллага болон хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газрын гишүүдийг” гэснийг “байгууллагын гишүүдийг” гэж, 3.2 дахь заалтын “гадаад хэргийн яам, олон улсын болон хэвлэл мэдээллийн байгууллагын” гэснийг “гадаад харилцааны яам болон олон улсын байгууллагын” гэж, 2.1.3 дэд заалтын дугаарыг “2.1.ж” гэж, 4.7.2.е дэд заалтын дугаарыг “4.7.2.д” гэж тус тус өөрчилсүгэй.

5. Мөн журмын 1.6 дахь заалт, 2.1.ж заалт, 4.7.2.д дэд заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**

**Д.ЦОГТБААТАР**

Засгийн газрын 2019 оны 64 дүгээр  
тогтоолын хавсралт

**ГАДААДЫН СУРВАЛЖЛАГЧИЙГ БҮРТГЭХ, МОНГОЛ УЛСЫН  
ВИЗ, ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах гадаад улсын, олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газарт болон түүнийг төлөөлж ажиллах хэвлэл мэдээллийн ажилтан (цаашид “гадаадын сурвалжлагч” гэх), түүний гэр бүлийн гишүүнийг бүртгэх, виз, визийн зөвшөөрөл, гадаадын сурвалжлагчийн үнэмлэх (цаашид “үнэмлэх” гэх) болон Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгох буюу татгалзах, тэдгээрийн хугацааг сунгах, хүчингүй болгоход Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын виз олгох журам, Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам болон энэ журмыг мөрдөнө.

1.2. Монгол Улсад зохион байгуулах хурал, чуулга уулзалт, дээд, өндөр түвшний айлчлал зэрэг дотоодын болон олон улсын арга хэмжээг төрийн байгууллагын урилгаар сурвалжлах гадаадын сурвалжлагч нь энэ журмын дагуу зөвшөөрөл, үнэмлэх авах шаардлагагүй.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэ журам нь дор дурдсан гадаадын сурвалжлагч, түүний гэр бүлийн гишүүнд үйлчилнэ:

2.1.1. Монгол Улсад 90 хүртэл хоногийн хугацаагаар ирсэн гадаад улсын болон олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагын албан ёсны ажилтан, гэрээт ажилтан болон зураглаач, гэрэл зурагчин, дууны инженер, ерөнхий редакторын туслах зэрэг техник ажилтан;

2.1.2. Монгол Улсад 90 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаад улсын болон олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагын албан



ёсны ажилтан, гэрээт ажилтан, зураглаач, гэрэл зурагчин, дууны инженер, ерөнхий редакторын туслах зэрэг техник ажилтан, түүний гэр бүлийн гишүүн.

2.2. Энэ журмын 2.1.2-т заасан “гэр бүлийн гишүүн” гэдэгт эхнэр буюу нөхөр, 18 хүртэлх насны, эцэг эхтэйгээ хамт амьдардаг, төрүүлсэн болон албан ёсоор үрчилж авсан хүүхдийг хамааруулна.

Гурав. Гадаадын сурвалжлагчийн зөвшөөрөл, үнэмлэх олгох, хүчинтэй хугацааг сунгах

3.1. Энэ журмын 2.1-д заасан гадаадын сурвалжлагч Монгол Улсад байнгын болон түр сурвалжлагчаар ажиллах хүсэлтээ гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад сурталчилгаа хариуцсан нэгжид холбогдох Дипломат төлөөлөгчийн газар, өөрийгөө төлөөлж байгаа байгууллагаар дамжуулан, эсхүл биечлэн гаргаж болно. Хүсэлт гаргахдаа дараахь баримт бичгийг бүрдүүлэн энгийн болон цахим шуудангаар хүргүүлнэ:

3.1.1. Монгол Улсад байнга, эсхүл түр хугацаагаар томилон ажиллуулах тухай харьяа хэвлэл мэдээллийн байгууллагын албан бичиг;

3.1.2. гэрээний үндсэн дээр ажиллаж байгаа гадаадын сурвалжлагч нь гадаад улсын болон олон улсын хэвлэл мэдээллийн тухайн байгууллагын тодорхойлолт, албан бичиг;

3.1.3. гадаад паспортын хуулбар;

3.1.4. мэдүүлгийн хуудас;

3.1.5. 3,5смх4,5см хэмжээтэй 2 хувь цээж зураг.

3.2. Монгол Улсад байнгын сурвалжлагчаар ажиллах гадаадын сурвалжлагчийн гэр бүлийн гишүүн энэ журмын 3.1.1-3.1.5-д заасан баримт бичгээс гадна тухайн сурвалжлагчийн гэр бүлийн гишүүн мөн болохыг нотлох баримт бичиг буюу “Монгол Улсын виз олгох журам”-ын 2.6.5-д заасан баримт бичгийг хавсаргана.

3.3. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад сурталчилгаа хариуцсан нэгж хүсэлтийг хянаж, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн эсэх тухай хариуг гадаадын сурвалжлагчид ажлын 5 хоногт багтаан тухайн улс дахь Дипломат төлөөлөгчийн газар, өөрийг нь төлөөлж буй байгууллагаар нь дамжуулан, эсхүл цахим шуудангаар шууд мэдэгдэнэ.

3.4. Гадаадын сурвалжлагч энэ журмын 3.1, 3.2-т заасан баримт бичгийг дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдвол гадаадын сурвалжлагчийн зөвшөөрөл, гадаадын сурвалжлагчийн үнэмлэх олгохоос татгалзана.

3.5. Гадаадын сурвалжлагч, түүний гэр бүлийн гишүүн Монгол Улсад ирсэн өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад сурталчилгаа хариуцсан нэгжид өөрийн биеэр ирж, гадаадын сурвалжлагчийн үнэмлэхээ авна. Хэрэв хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр бүртгүүлээгүй тохиолдолд гадаадын сурвалжлагчийн үнэмлэх олгохгүй.

3.6. Гадаадын сурвалжлагчийн үнэмлэхийн хүчинтэй хугацаа нь түүний Монгол Улсад зорчих виз буюу оршин суух зөвшөөрлийн хугацаатай адил байна.

3.7. Гадаадын сурвалжлагч үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгах хүсэлтээ хугацаа нь дуусахаас ажлын 7 хоногийн өмнө энэ журмын 3.1.1-3.1.2-т заасан баримт бичгийн хамт гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад сурталчилгаа хариуцсан нэгжид гаргана.

3.8. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад сурталчилгаа хариуцсан нэгж гадаадын сурвалжлагчийн үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгах эсэхийг энэ журмын 3.1.1-3.1.2-т заасан баримт бичигт үндэслэн ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.

3.9. Монгол Улсын иргэн гадаад улсын болон олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагын Монгол Улс дахь байнгын сурвалжлагчаар ажиллах тохиолдолд байнгын сурвалжлагчаар томилсон хэвлэл мэдээллийн тухайн байгууллагын тодорхойлолт, ажлын үнэмлэхийг үндэслэн гадаадын сурвалжлагчийн үнэмлэх олгож болно.

3.10. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний хүрээнд Монгол Улсад визгүй зорчих улсын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд энэ журмын 4.1-д заасны дагуу гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад сурталчилгаа хариуцсан нэгжийн зөвшөөрлөөр Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газарт виз мэдүүлж, урьдчилан виз авсан байна. Монгол Улсад ирсэн өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад сурталчилгаа хариуцсан нэгжид өөрийн биеэр ирж, гадаадын сурвалжлагчийн үнэмлэх авна.



3.11. Гадаадын түр болон байнгын сурвалжлагчийн үнэмлэхийн загварыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Дөрөв. Гадаадын сурвалжлагчид виз, оршин суух зөвшөөрөл олгох, хугацааг нь сунгах

4.1. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгж энэ журмын 3.3-т заасан шийдвэрийг үндэслэн гадаадын сурвалжлагч болон түүний гэр бүлийн гишүүнд виз олгохыг зөвшөөрсөн тохиолдолд визийн зөвшөөрлийг тухайн гадаад улсад суугаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар, Өргөмжит консулд хүргүүлнэ.

4.2. Гадаадын сурвалжлагч энэ журмын 4.1-д заасан виз олгох эрх бүхий байгууллагад виз мэдүүлэхдээ “Монгол Улсын виз олгох журам”-ын 4.9-д заасан баримт бичгийг бүрдүүлнэ.

4.3. Энэ журмын 4.1-д заасан виз олгох эрх бүхий байгууллага нь энэ журмын 4.1, 4.2-т заасан баримт бичгийг үндэслэн гадаадын сурвалжлагч болон түүний гэр бүлийн гишүүнд Монгол Улсад зорчих виз олгоно.

4.4. Монгол Улсад оршин суух гадаадын сурвалжлагч болон түүний гэр бүлийн гишүүн нь Монгол Улсад ирсэн өдрөөс хойш ажлын 7 хоногийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ёслолын асуудал хариуцсан нэгжид бүртгүүлж, оршин суух зөвшөөрөл хүснэ.

4.5. Гадаадын сурвалжлагч энэ журмын 4.4-т зааснаар оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ын 3.5-д заасан баримт бичгийг бүрдүүлнэ.

4.6. Монгол Улсад оршин суух гадаадын сурвалжлагч болон түүний гэр бүлийн гишүүний оршин суух зөвшөөрлийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ёслолын асуудал хариуцсан нэгж ажлын 5 хоногт багтаан олгож, консулын асуудал хариуцсан нэгж зохих визийг олгоно.

4.7. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ёслол, консулын асуудал хариуцсан нэгж энэ журмын 3.8-д заасан шийдвэрийг үндэслэн гадаадын сурвалжлагч болон түүний гэр бүлийн гишүүний виз болон оршин суух зөвшөөрлийн хугацааг ажлын 5 хоногт багтаан сунгана.

4.8. Гадаадын сурвалжлагч хүүхэд төрүүлсэн, хууль ёсоор үрчилж авсан бол энэ тухайгаа гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ёслол, консулын асуудал хариуцсан нэгжид мэдэгдэж, түүнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл, виз авахаар мэдүүлнэ.

4.9. Энэ журамд заасан бүртгэх, оршин суух зөвшөөрөл, үнэмлэх олгоход аливаа төлбөр, хураамж авахгүй.

Тав. Гадаадын сурвалжлагчийн эрх, үүрэг

5.1. Энэ журмын 3.3, 3.5 дахь хэсэгт заасан зөвшөөрөл, үнэмлэхтэй гадаадын сурвалжлагч дараахь эрхтэй:

5.1.1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан мэдээллийг авах, сурвалжлах;

5.1.2. Монгол Улсын хуулиар хориглосноос бусад газарт чөлөөтэй зорчих;

5.1.3. Монгол Улсын байгууллага, иргэнтэй хэвлэл мэдээллийн чиглэлээр хамтын ажиллагааны гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж ажиллах;

5.1.4. хуульд заасан бусад эрх.

5.2. Энэ журмын 3.3, 3.5 дахь хэсэгт заасан зөвшөөрөл, үнэмлэхтэй гадаадын сурвалжлагч дараахь үүрэгтэй:

5.2.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас сурвалжлага авахдаа гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад сурталчилгаа хариуцсан нэгжээр дамжуулан зөвшөөрөл авах;

5.2.2. энэ журмын 5.2.1-д заасан улс төрийн албан тушаалтнаас авсан сурвалжлагыг олон нийтэд түгээхээс өмнө тухайн сурвалжлага нь үнэн, бодит байх үүднээс сурвалжлага өгсөн улс төрийн албан тушаалтан, эсхүл түүний хэвлэл мэдээллийн төлөөлөгчөөр хянуулах;

5.2.3. хилийн бүс болон бусад тусгай хамгаалалттай газарт зорчихдоо зохих зөвшөөрлийг холбогдох байгууллагаас урьдчилан авах;





5.2.4. Төрийн ордон, төрийн байгууллагад нэвтрэхдээ Монгол Улсын Төрийн ордны тухай хууль, “Монгол Улсын Төрийн ордны хамгаалалт, үйлчилгээний журам” болон тухайн байгууллагын журмыг мөрдөх;

5.2.5. мэдээллийн үнэн зөвийг нягтлах, хариуцах;

5.2.6. зөвшөөрөл, үнэмлэхийг гээгдүүлсэн, үрэгдүүлсэн тохиолдолд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад сурталчилгаа хариуцсан нэгжид нэн даруй мэдэгдэх;

5.2.7. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

**Зургаа. Гадаадын сурвалжлагчийн үнэмлэх, виз, оршин суух зөвшөөрлийг олгох, сунгахаас татгалзах, хүчингүй болгох**

6.1. Дараахь тохиолдолд гадаадын сурвалжлагч биечлэн өөрийгөө болон өөрийн гэр бүлийн гишүүнийг бүртгэлээс хасуулж, оршин суух зөвшөөрөл, үнэмлэхийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хураалгана:

6.1.1. гадаадын сурвалжлагч, түүний гэр бүлийн гишүүн бүрмөсөн буцсан;

6.1.2. гадаадын сурвалжлагч, түүний гэр бүлийн гишүүний Монгол Улсад оршин суух эрх зүйн байдал өөрчлөгдсөн;

6.1.3. төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа гадаадын иргэний хүүхэд гэр бүл болсон, 18 насанд хүрсэн бол.

6.2. Дараахь тохиолдолд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад сурталчилгаа хариуцсан нэгж нь гадаадын сурвалжлагч, түүний гэр бүлийн гишүүний гадаадын сурвалжлагчийн үнэмлэхийг хүчингүй болгож, виз, оршин суух зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзах, эсхүл хүчингүй болгож болно:

6.2.1. гадаадын сурвалжлагч энэ журмаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

6.2.2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, “Монгол Улсын виз олгох журам”-ын 5 дахь хэсэгт заасан үндэслэлээр.

Долоо. Бусад

7.1. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад сурталчилгаа хариуцсан нэгж нь гадаадын

сурвалжлагчдын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, бүртгэлийг хөтөлж, эрх бүхий байгууллагын хүсэлтээр гадаадын сурвалжлагчтай холбогдох баримт мэдээллийг гаргаж өгнө.

7.2. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад сурталчилгаа хариуцсан нэгж нь гадаадын сурвалжлагчид Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7, 8 дугаар зүйлд заасан эрх үүрэг, хориглох зүйлийг танилцуулна.

7.3. Энэ журмыг зөрчсөн иргэн, албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2019 оны 2 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар  
хот

### **Үндэсний хөтөлбөр батлах тухай**

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг үндэслэн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, орон нутагт дэд хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын төсвийн багцад жил бүр тусган, олон улсын байгууллага, гадаадын зээл тусламжид хамруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН САЙД**

**Ё.БААТАРБИЛЭГ**



Засгийн газрын 2019 оны 68 дугаар  
тогтоолын хавсралт

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Соёлын биет бус өв нь аливаа үндэстэн, угсаатны бүлэг, хамт олны оршин тогтнох, сэтгэх, бүтээж туурвих, амьдран хөгжих эх ундарга, амьдралын өвөрмөц төрх, зан үйл, хөгжил дэвшлийнх нь нэгэн илэрхийлэл болж, өргөн утгаараа тухайн улс, үндэстний үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлж байдаг учраас соёлын биет бус өвийг хадгалан хамгаалах, өвлөн уламжлуулах, дэмжих талаар дэлхий нийтээр ихээхэн анхаарч байна.

Монгол Улс ЮНЕСКО-гийн 2003 оны “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц”-д 2005 онд нэгдсэн орсон бөгөөд оролцогч улс бүр өөрийн нутаг дэвсгэр дээрх соёлын биет бус өвийг хамгаалах үүрэг хүлээж байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Монгол хэлний тухай хуулиудад уламжлалт соёлоо хадгалж хамгаалах, өвлөн уламжлах, баяжуулан хөгжүүлэх, судалж сурталчлах талаар тодорхой заалтуудыг тусгасан байна.

2014 онд Соёлын өвийг хамгаалах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг баталж, соёлын биет бус өвийн 15 ангилал, өвлөн уламжлагчийн эрх, үүрэг болон тэднийг урамшуулах, өвлөн уламжлуулах үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг харилцааг зохицуулахаар тусгасан байна.

2005-2016 онд ЮНЕСКО-гийн “Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт”-д бүртгэгдсэн морин хуур, уртын дуу, хөөмий, “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт”-д бүртгэгдсэн уламжлалт бүжиг-бий биелгээ, тууль, цуурын урлагийг хадгалж хамгаалах үндэсний хөтөлбөрүүдийг Засгийн газар батлан хэрэгжүүлсний үр дүнд иргэд, ахмад үеийн төлөөллөөс соёлын биет бус өвийн өвлөн

уламжлагчийг тодруулах, шавь сургалт зохион байгуулах, гадаад, дотоодод үндэсний өв соёлоо таниулан, хүүхэд залууст өв соёлоо өвлүүлэн үлдээх, бахархах үзлийг төлөвшүүлэх, энэ чиглэлд бие даан судалгаа хийж, түгээн дэлгэрүүлэх зэрэг эерэг өөрчлөлтүүд бий болсон байна.

Гэвч соёлын биет бус өвийн 5 ай савын зөвхөн “Ардын язгуур урлаг”-ийн ай савыг тэргүүлэх чиглэлд авч үзсэн нь соёлын биет бус өвийн конвенцид тусгасан “эх хэл болон аман уламжлал”, “үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам”, “байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга технологи” болон “гар урлал” гэсэн бусад ай савд хамаарах өвийг хадгалж, хамгаалах бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг хангаж чадаагүй байна.

Иймд Монгол Улс ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд бүртгүүлсэн өв соёлоор хязгаарлагдахгүйгээр нүүдэлчдийн өв соёлыг бүрэн илэрхийлэхүйц соёлын биет бус өвийн ай сав бүрт хамаарах биет бус өвийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл судалгаа шинжилгээг өргөжүүлэх, гадаад дотоодод сурталчлан таниулах, өвлөн уламжлагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх замаар нийгэм, эдийн засгийн үнэлэмжийг дээшлүүлж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний хэлбэрээр соёлын үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжийг бий болгон, соёлын биет бус өвийн төрөл зүйлийг цогцоор нь хамгаалах шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа монгол угсаатны олон бүлгийн соёлын биет бус өвийг олж илрүүлэх, судлах, бүртгэн баримтжуулах, хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн хүрээнд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1. соёлын биет бус өвийн талаар баримтлах бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, соёлын биет бус өвийг хамгаалах конвенцийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;

2.2.2. соёлын биет бус өвийн судалгаа, бүртгэн баримтжуулалт, бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэж, боловсронгуй болгох;



2.2.3. соёлын биет бус өвийн талаар бүх нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг салбар хоорондын хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулах;

2.2.4. соёлын биет бус өвийн мэргэжилтнийг чадавхжуулах, өвлөн уламжлагчдыг дэмжих.

### 2.3. Хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Соёлын биет бус өвийн талаар баримтлах бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, соёлын биет бус өвийг хамгаалах конвенцийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.1.1. соёлын биет бус өвийг хамгаалах чиглэлээр олон улсад мөрдөж байгаа хууль, эрх зүйн орчныг судалж, соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох;

3.1.2. соёлын биет бус өвийг хамгаалах дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулах;

3.1.3. Монгол үндэсний соёлын биет бус өвийг олон улсад түгээн дэлгэрүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах;

3.1.4. “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц”-ийн хэрэгжилтийг хангаж, соёлын биет бус өвийг бүртгүүлэх, хамгаалах ажлыг сайжруулах.

3.2. Соёлын биет бус өвийн судалгаа, бүртгэн баримтжуулалт, бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэж, боловсронгуй болгох хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.2.1. орон нутагт олон угсаатны бүлгийн хүрээний соёлын биет бус өвийн иж бүрэн судалгаа хийж, үзлэг зохион байгуулан, үндэсний жагсаалтыг боловсронгуй болгох;

3.2.2. соёлын биет бус өвийн бүртгэн баримтжуулалтын арга зүй, бүртгэл мэдээллийн сангийн нэгдсэн сүлжээг бий болгож, судалгаа, эрдэм шинжилгээ, боловсролын үйл ажиллагаанд ашиглах боломжийг бүрдүүлэх;

3.2.3. соёлын өвийн бүх шатны байгууллагын дэргэдэх бүртгэл, мэдээллийн санг орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, цахим хэлбэрт шилжүүлэх.

3.3. Соёлын биет бус өвийн талаар бүх нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг салбар хоорондын хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулах зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.3.1. соёлын биет бус өвийг гадаад, дотоодод сурталчлан түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлж, олон улсын болон үндэсний хэмжээнд уралдаан, наадмыг зохион байгуулан, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох;

3.3.2. соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг оролцоог нэмэгдүүлж, үндэсний агуулгатай контент бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх замаар хамтын ажиллагааг сайжруулах;

3.3.3. бүх нийтийн соёлын биет бус өвийн мэдлэг, ойлголтыг албан ба албан бус боловсролын хөтөлбөрөөр дамжуулан нэмэгдүүлэх;

3.3.4. соёлын биет бус өвийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, дэвшилтэт технологи, цахим сүлжээг хөгжүүлэх.

3.4. Соёлын биет бус өвийн мэргэжилтнийг чадавхжуулах, өвлөн уламжлагчдыг дэмжих зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.4.1. олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судлаач, шинжээч, мэргэжилтэн, мэргэшсэн албан хаагчдыг бэлтгэх, давтан сургах сургалтын тогтолцоог сайжруулах;



3.4.2. соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэн, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, шавь сургалтад мэргэжил арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэн, олон нийтэд таниулан алдаршуулах.

Дөрөв. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэм-жих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	
				Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
Бодлогын баримт бичгийн үр дүнг үнэлэх бусад шалгуур үзүүлэлтүүд							
1	1. Соёлын биет бус өвийн талаар баримтлах бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, соёлын биет бус өвийг хамгаалах конвенцийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	судлагдсан эрх зүйн баримт бичигт санал өгсөн байдал	тоо	2019	1	2023	2
		шинээр болон шинэчлэгдэн батлагдсан дүрэм, журам	тоо	2019	1	2023	4
		гадаад улс орнуудтай байгуулсан гэрээ хэлэлцээр		2019	1	2023	3
		ЮНЕСКО-д бүртгүүлсэн өв	тоо	2019	14	2023	16
2	2. Соёлын биет бус өвийн судалгаа, бүртгэн баримтжуулалт, бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэж, боловсронгуй болгох	үзлэг, судалгаа	тоо	2019	-	2023	2
		мэдээллийн сангийн баяжилт, цахим сан үүсгэлт	тоо	2019	-	2023	2
		тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллага	хувь	2019	10%	2023	70%



3	3. Соёлын биет бус өвийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг салбар хоорондын хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулах	зохион байгуулсан уралдаан, наадам, түүнд хамрагсад	тоо	2019	1/550	2023	2/1200
		үндэсний агуулгатай монгол уран бүтээлийн эзлэх хувь	хувь	2019	10%	2023	60%
		соёлын өвийн гарын авлага, хөтөлбөр	тоо	2019	2	2023	8
		соёлын үйлдвэрлэлийн чиглэлээр хэрэгжсэн төсөл, нэвтрүүлсэн дэвшилтэт технологи	тоо	2019	15	2023	40
4	4. Соёлын биет бус өвийн мэргэжилтнийг чадавхжуулах, өвлөн уламжлагчдыг дэмжих	өвлөн уламжлагч зохион байгуулсан сургалт, түүнд хамрагсад	тоо	2019	98	2023	120
		шинэ залуу уран бүтээлчдийг дэмжсэн арга хэмжээ	тоо	2019	5	2023	10
		шавь сургалтад суралцагчид	тоо	2019	2	2023	22
		Соёлын биет бус өвийг сурталчилсан байгууллага	тоо	2019	-	2023	8
		зохион байгуулсан сургалт, түүнд хамрагсад	тоо	2019	3/120	2023	10/500

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:





- 5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 5.1.2. гадаадын зээл, буцалтгүй тусламж;
- 5.1.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 5.1.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив;
- 5.1.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

**Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн  
хяналт-шинжилгээ, үнэлгээ**

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг соёл, урлагийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага жил бүр зохион байгуулж, тайланг дараа оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

6.2 Хяналт, шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

**Хаяг:**  
“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)  
**Утас:** 262420  
Хэвлэлийн хуудас: 1.5  
**Индекс: 200003**